

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2023-06-13

Бүтэц	№	Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Төлөвлөсөн онд хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Хувь
						2023		
Үндсэн чиг үүргийн нэр: 6 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих								
Зорилт	1	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд 86.7 хувьд хүргэнэ.	Хандив тусламж 132,4 сая Улсын төсөв 14,5 сая	Тоног төхөөрөмжийн хангалтын хувь	85.0	86.0	Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудад 8 нэр төрлийн 166,8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьтай байна.	100
Арга хэмжээ	1	Сумдын эрүүл мэндийн төвүүдийг мобайл технологиор хангах	Хандив тусламж 8,0 сая	Хангагдсан сумдын тоо	4	4	Адаацаг сумын эрүүл мэндийн төвд хувь хүний хандив тусламжаар 8,0 сая төгрөгийн мобайль технологитой болсон. Ингэснээр нийт 12 сумын эрүүл мэндийн төвүүдэд мобайль технологитой болсон.	100
	2	Эмнэлэг эрүүл мэндийн төвүүдийг оношилогоо, эмчилгээний дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах	Хандив тусламж 132,4 сая Улсын төсөв 14,5 сая ДЭМБ-ын санхүүжилт 16,0 сая Хандив тусламж 3,9 сая	Тоног төхөөрөмжийн хангалт Хувь	85.0	86.5	Япон Улсын Засгийн газраас “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 128,5 сая төгрөгийн 14 ширхэг спирометрийг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хувиарлан өглөө. Өндөршил, Хулд сумын эрүүл мэндийн төвүүд хог хаягдал ангилан ялгах путик, ор, өвчтний хоолны шкафыг улсын төсөв бүхий 14,5 сая төгрөгөөр	100

							худалдан авсан. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн буцалтгүй тусламж 3,9 сая төгрөгийн 35 ширхэг пульсоксиметрийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хувиарлан өглөө. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газарт Шуурхай удирдлагын нэгж байгуулах 16,0 сая тоног төхөөрөмжөөр хүлээлгэн өглөө. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сангийн буцалтгүй тусламж 3,9 сая төгрөгийн 35 ширхэг пульсоксиметрийг аймгийн Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны Нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хувиарлан өглөө. Тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьтай.	
3	Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн автомашины парк шинэчлэлт, багийн эмч нарын унааг үе шаттай хийж, түргэн тусламжийн автомашиныг яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглох	ОНХС 40,0 сая Хандив тусламж 60,0 сая Улсын төсөв 25,0 сая	Автомашины хангалт хувь	90	94	Сайнцагаан, Өлзийт-Мандал өрхийн эрүүл мэндийн төвд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 40,0 сая төгрөгийн үнэ бүхий түргэн тусламжийн үйлчилгээг хүргэх суудлын автомашинаар хангалаа. Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс Луус сумын эрүүл мэндийн төвд пургон автомашин, Луус, Өлзийт сумын эрүүл мэндийн төвд аймгийн мэргэжлийн хяналтын газраас	66,6	

							аксент маркын автомашин Орон нутгийн өмчийн газраас шууд шилжүүллээ. Нийт автомашины хангалт 95,0 хувьд хүрсэн байна.	
				Тоногдсон автомашины тоо	1	2	Нарлаг Монголын тээвэр зууч "Нямхишиг транс" ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгт 60,0 сая төгрөгийн бүрэн тоноглогдсон автомашин өглөө. Тоноглогдсон автомашины тоо 6 болсон.	
				Багийн эмчийн унааны тоо	1	10	Багийн эмчийн унааны асуудал шийдэгдээгүй болно.	
Зорилт	2	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг 2020 онд 83.0 байсныг 2024 онд 85.0 хүргэнэ.	Улсын төсөв 5 сая	Чанарын үзүүлэлтийн Хувь	83.0	84.5	Эхний хагас жилийн байдлаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлт 91,0 хувьтай байна	100
Арга хэмжээ	1	Явуулын тусламж, үйлчилгээгээр алслагдсан сум багийн иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Улсын төсөв 2,5 сая Глобал сан 6,0 сая	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн эзлэх хувь	29.7	32.5	Явуулын тусламж үйлчилгээг алслагдсан сумдын багийг иргэдийг хамруулах хүрээнд Аймгийн Засаг дарыгн санаачилгаар аймгийн хэмээний нийт 14 суманд нарийн мэргэжлийн 6 эмч нарын үзлэг шинжилгээ оношилгоог зохион байгууллаа. Үзлэг оношилгоо, шижнилгээг нийт 3526 иргэнийг хамруулсан байна. Үзлэгээр хоол боловсруулах замын эмгэг 51 хувь, цагаан судлалын өвчин буюу нуруу нугасны шохойжилт 41 хувьтай зонхилж байна. Элэгний хавдар 2, элэгний үүсгэвэр 2, элэгний хатуурал 3, элэгний өөхжилт 19, уушигны өөрчлөлттэй 14 бусад өвчлөл 789 илэрсэн байна. Өвчлөл илэрсэн иргэдийг 2 дахь болон 3 дахь шатлалын эмнэлэгт илгээж,	100
				Өвчлөл илэрсэн иргэдийн эрүүлжилтийн хувь	26.0	28.0		

							эрүүлжилт 25,0 хувьтай байна. Нийт иргэдийн 11,5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.	
2	Хот хоорондын зам дагуу болон алслагдсан сумдад яаралтай тусламжийн цэг байгуулах	Улсын төсөв 3,5 сая	Цэг байгуулсан сумдын тоо	1	1		Хулд, Дэлгэрцогт, Луус сумдад нийт яаралтай тусламжийн 3 цэгийг байгуулан тогтмолжуулан ажиллаж байгаа бөгөөд авто осол 17, бусдад зодуулсан 2, түлэгдэлт 1, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 3, ахуйн осол 3 мотоциклоос унасан 1, явганаас унасан 1 тус тус чиглэлээр нийт 28 хүнд буюу 100 хувь тусламж үйлчилгээ үзүүлсэн	100
3	Олон улсын эмнэл зүйн UP TO DATE програмыг эмч бүр ашиглах, алсын зайн оношлогоо, зөвлөгөө авах нөхцөлийг бүрдүүлж эмч нарыг компьютер тоног төхөөрөмжөөр хангах	-	Ашиглалтын хувь	0	100		Олон улсын эмнэл зүйн UP TO DATE цахим платформыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн 100 хувь нь ашиглаж байна. Эхний хагас жилийн байдлаар алсын зайн оношилгоо, зөвлөгөөг төрөлжсөн нарийн мэргэжлийн төвөөс 6 удаа авсан.	100
			Хангалтын хувь	45	100		Эрүүл мэндийн төвүүдэд оношилгоо, эмчилгээ, зөвлөгөө, бүртгэл мэдээлэлд зориулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 16,5 сая төгрөгийн үнэ бүхий суурин 15 компьютероор хангаж нийт 56 болсноор эмч нар 100 хувь хангагдлаа.	
4	Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах	Улсын төсөв 4,6 сая	Эхийн эндэгдэл /100 000 амьд төрөлт/Просантим иль	0	0		Эхний 5 сарын байдлаар нийт 294 эх төрсөн бөгөөд нийт төрөлтийн 93,8 хувь нь аймгийн нарийн мэргэжлийн эмчийн хяналтад төрсөн. Эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй.	50
			5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	10.0	9.5		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 10,1 промилль байна.	

				/1000 амьд төрөлт/Промиль			Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6,5 промилиор өссөн үзүүлэлттэй байна.	
Зорилт	3	Халдварт бус өвчлөлийн түвшинг 2020 оны 7441.5 байсныг 2024 онд 7241.5 болгож бууруулна.	Улсын төсөв 200,1 сая	10000 хүн амд ногдох халдварт бус өвчлөлийн түвшин Промиль	7441.5	7291.5	Халдварт бус өвчлөлийн түвшин 10000 хүн амд 5141,9 ногдож байна.	100
Арга хэмжээ	1	Иргэн, өрх гэр бүл, байгууллага, хамт олонд түшиглэн эрүүл мэндэд ээлтэй орчинг бүрдүүлэх.	Улсын төсөв 1,3 сая	Эрүүл мэндийг дэмжигч эрүүл мэндээ дээдлэгч иргэний тоо	37	46	“Эрүүл мэндээ дээдлэгч иргэн” , “Эрүүл мэндийн дэмжигч байгууллага” шалгаруулах болзолт уралдааныг зарлах журам, шалгуур үзүүлэлтийг эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлээд байна. 2023 оны 10 дугаар сард шалгаруулж дүгнэнэ.	100
				Хог хаягдлын автоклаваар хангагдсан ЭМБ-ын тоо	0	9	Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд 11 ширхэгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хангагдлаа.	
	2	Хүн амын дунд өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөлийг бууруулах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх .	Улсын төсөв 200,1 сая	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын хувь	29.7	33.8	Эрүүл мэндийн байгууллагуудаар нийт 76050 хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 17332 буюу 22,7 хувьтай байна.	72,9
				Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь	57.8	65.0	Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд 2023 оны 5 сарын байдлаар 0-5 насны багцад 3391 хамрагдаж 54.0%, 6-17 насны багцад 7811 хамрагдаж 75.6%, 18 дээш насны 4 багцад 5666 хамрагдаж 18.5% байна. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтын хувь 35,7%-тай байна. Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл	

						<p>артерийн даралтыг эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 10118 иргэнээс 3991 буюу (39.4%), чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 10910 иргэн хамрагдахаас 3941 буюу (36.1%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 2376 иргэн хамрагдахаас 591 буюу (24.9%), хөхний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт 7449 иргэн хамрагдахаас 1899 буюу (25.5%) хамрагдаж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 31.4%-тай байна. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн даралттай 21, чихрийн шижинтэй 6 иргэнийг тус тус илрүүлэн хяналтад авч эмчилж байна. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын дундаж 33,5 хувьтай байна.</p>	
				<p>Эрүүл мэндийн боловсрол олгосон хүн амын эзлэх хувь</p>	59.4	74.4	<p>Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүд болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс гаргасан 2023 онд зохион байгуулах тэмдэглэлт өдрүүдийн сургалт сурталчилгааны төлөвлөгөөг тус тус үндэслэн аймгийн хэмжээнд энэ онд хэрэгжүүлэх иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны календарчилсан нэгдсэн төлөвлөгөөг гарган ажиллаж эхний 5 сарын байдлаар нийт 352</p>

							удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 68621 иргэнд эрүүл мэндийн эрүүл мэндийн боловсрол олгосон байна. Иргэдийн оролцооны хувь 100	
3	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагааг өргөжүүлэх.	Хандив тусламж 132,4 сая	Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн хангалтын хувь	50.0	58.0	Коронавируст халдварын батлагдсан шинэ тохиолдол 103 өссөн дүнгээрээ 15900 байна. Өнөөдрийн байдлаар гэрээр эмчлэгдэж байгаа 7 иргэн, эмнэлэгт 2 иргэн (2 том хүн) хөнгөн хэлбэрээр эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байна. Коронавируст халдварын тархалт “Ногоон” буюу тархалт бага/тогтвортой” түвшинд байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн хангалт 85,8 байна. Гамшгийн үеийн хүний нөөцийн хангалт 91,0 хувьтай байна.	98,6	
			Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь	78.0	85.0	Сум өрхийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 82,0, Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалт 94,0 Аймгийн хэмжээнд тоног төхөөрөмжийн хангалт 88,0 хувьтай байна.		
			Дархлаажуулалтын хамралтын хувь	94.4	96.0	Заавал хийх товлот дархлаажуулалтад хамрагдвал зохих нийт 2255 хүүхдээс хамрагдсан 2077 хүүхдийг хамрууллаа. Хамралт 92,1%-тай байна.		
							ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ-	91,4

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР